



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх гэрэлтүүлэг чимэглэлийн алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/006/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn Цахим актив аудит ХХК-ийн захирал: Л.Амарзаяа Утас: 88501881 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

᠑᠒᠒᠑.᠐᠖.14 № ᠐᠒/25᠐
танай _____-ны № _____-т

НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ГЭРЭЛТҮҮЛЭГ ЧИМЭГЛЭЛИЙН
АЛБА ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Г.БАЯРСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайх гэрэлтүүлэг чимэглэлийн алба ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 347,529.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Налайх дүүргийн Засаг даргын тамгын газраас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 328,009.9 мянган төгрөгийн гэрэлтүүлгийн сэлбэг

᠑᠒᠒᠑᠐᠖᠒᠐᠒᠒

хэрэгслийг тус байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлснийг бараа материалын данс бүртгэлд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тод бүрэн мэдээлэл байршуулаагүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 40 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 96.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ЗОРИЛТОТ ТҮВШИН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/Төгрөгөөр

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	644,484.28	137,425.48
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	3,052,499.39	11,875,516.08
1.1.6	Бараа материал	38,958,827.00	306,440,350.53
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	42,655,810.67	318,453,292.09
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,553,258,301.52	3,021,319,369.21
1.2.2	Биет бус хөрөнгө	12,168,750.00	11,550,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,565,427,051.52	3,032,869,369.21
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,608,082,862.19	3,351,322,661.30
2.1.1.1	Дансны өглөг	51,391,238.66	75,040,976.67
2.1.1.2	Цалингийн өглөг	(0.00)	73,434.51
2.1.1.3	Татварын өр	(0.00)	980,160.19
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	51,391,238.66	76,094,571.37
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,350,448,419.27	2,677,573,536.55
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,350,448,419.27	2,677,573,536.55
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,401,839,657.93	2,753,668,107.92
2.3.1	Өмч: - төрийн	621,910,737.00	992,192,487.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	87,923,761.81	87,923,761.81
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	572,845,934.00	572,845,934.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,076,437,228.55)	(1,064,437,228.55)
2.3.10	Тайлант үеийн үр дүн	0.00	9,129,599.12
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	206,243,204.26	597,654,553.38
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	2,608,082,862.19	3,351,322,661.30

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/Төгрөгөөр/

Мөр		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	999,235,781.82	1,248,949,312.73
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	798,389,092.82	901,438,211.63
3	Нийт ашиг (алдагдал)	200,846,689.01	347,511,101.10
5	Хүүний орлого	97,480.00	342,397.11
8	Бусад орлого	1,196,464,849.75	1,365,642,868.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,449,785,682.71	1,702,643,402.91
12	Бусад зардал	66,019.69	337,715.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(6,383,480.79)	(371,250.01)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(58,826,164.33)	10,143,999.01
19	Орлогын татварын зардал	0.00	1,014,399.89
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(58,826,164.33)	9,129,599.12
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(58,826,164.33)	9,129,599.12
24	Орлогын нийт дүн	(58,826,164.33)	9,129,599.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/Төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,004,211,670.82	1,262,587,785.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	120,000.00	1,560,800.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		12,000,000.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,290,699.00	7,768,890.00
	Татаас, санхүүжилтын орлого	970,915,800.00	1,220,799,500.00
	Бусад мөнгөн орлого	22,885,171.82	20,458,595.00
1.2	Мөнгөн зарлага (-)	1,001,919,640.53	1,204,908,940.91
	Ажиллагчдад төлсөн	189,274,105.00	246,966,144.50
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	59,487,324.30	76,157,413.84
	Бараа материал худалдан авахад төлсөн	258,159,369.00	333,559,101.00
	Ашиглалтын зардалд төлсөн	354,661,648.59	415,983,490.02
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	69,832,633.00	69,404,769.00
	Хүүний төлбөрт төлсөн	8,600.00	33,565.62
	Татварын байгууллагад төлсөн	21,341,810.95	25,411,896.93
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	114,750.00
	Бусад мөнгөн зарлага	49,154,149.69	37,277,810.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,475,871.57	57,678,844.09
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	89,987.34	661,597.11
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		319,200.00
	Хүлээн авсан хүүний орлого	89,987.34	342,397.11
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,759,900.00	58,847,500.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,759,900.00	58,847,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,669,912.66)	(58,185,902.89)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	622,117.63	(507,058.80)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,366.65	644,484.28
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	644,484.28	137,425.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	621,910,737.00	0.00	0.00	87,923,761.80	0.00	572,845,934.00	(1,017,611,064.22)	265,069,368.58
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(58,826,164.33)	(58,826,164.33)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	621,910,737.00	0.00	0.00	87,923,761.80	0.00	572,845,934.00	(1,076,437,228.55)	206,243,204.25
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	12,000,000.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	992,192,487.00	0.00	0.00	87,923,761.81	0.00	572,845,934.00	(1,064,437,228.55)	588,524,954.26
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	9,129,599.12	9,129,599.12
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	992,192,487.00	0.00	0.00	87,923,761.81	0.00	572,845,934.00	(1,055,307,629.43)	597,654,553.38

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл /мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Татаас, санхүүжилтийн орлого	913,915.8	1,170,799.5	1,170,799.5	0.0	100.0
2	Үйл ажиллагааны бусад орлого	20,892.5	10,000.0	20,723.3	10,723.3	207.2
3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	7,525.0	7,700.0	7,768.9	68.9	100.9
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,196,464.8	1,196,581.0	1,365,642.9	169,061.9	114.1
5	Засаг даргын санхүүжилт	57,000.0	-	50,000.0	50,000.0	
	Нийт орлогын дүн	2,195,798.1	2,385,080.5	2,614,934.6	229,854.1	109.6
1	Ажиллагчдын цалингийн зардал	229,001.5	418,967.0	271,125.3	(147,841.7)	64.7
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	33,104.7	52,370.9	76,157.4	23,786.5	145.4
3	Гэрэл, цахилгааны зардал	380,801.3	372,712.8	432,130.0	59,417.2	115.9
4	НЭ-н гэрэлтүүлгийн засварын зардал	353,847.1	243,145.5	401,370.9	158,225.4	165.1
5	Дулааны зардал	3,791.3	3,257.5	4,962.8	1,705.3	152.3
6	Цэвэр, бохир усны зардал	844.6	937.6	944.7	7.1	100.7
7	Тээвэр, шатахууны зардал	51,291.0	79,898.4	44,020.3	(35,878.1)	55.1
8	Сэлбэг хэрэгслийн зардал	12,632.7	14,360.0	15,988.6	1,628.6	111.3
9	Бичиг хэргийн зардал	1,636.5	2,596.2	2,021.1	(575.1)	77.8
10	Шуудан, харилцаа холбоо	1,642.4	1,481.0	1,601.5	120.5	108.1
11	Аж ахуйн дотоод хэрэгцээ	8,203.9	-	5,196.9	5,196.9	-
12	Түрээсийн зардал	5,520.0	8,400.0	10,650.0	2,250.0	126.8
13	ҮХ-н элэгдлийн зардал	1,158,591.7	1,158,591.7	1,326,074.2	167,482.5	114.5
14	НУ-н тэтгэмж, урамшуулал	2,550.0	-	1,553.0	1,553.0	-
15	Бусад зардал	2,926.0	3,712.0	8,665.5	4,953.5	233.4
16	ҮХ аш-с хассаны алдагдал	6,383.5	-	371.3	371.3	-
17	Албан татвар, төлбөр хураамж	1,856.2	2,081.4	1,957.0	(124.4)	94.0
18	Татварын зардал	-	-	1,014.4	1014.4	
	Нийт зардлын дүн	2,254,624.3	2,362,512.0	2,605,804.5	(243,292.5)	110.3
	Цэвэр ашиг	(58,826.2)	(22,568.4)	9,129.6	(13,438.8)	(40.4)

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 52,320.0 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлангаар 9,948.9 мянган төгрөгийн татварын авлагыг тооцооны үлдэгдлийн баталгаатай тулган баталгаажуулж тайлагнаагүй зөрүүтэй толилуулсаныг санхүү байдлын тайланд;
- Санхүүгийн орлого үр дүнгийн тайлангаар 945.9 мянган төгрөгийн орлогын албан татварын зардалыг алдаатай тайлагнасныг орлого үр дүнгийн тайланд;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу бүртгэл хөтлөөгүйгээс зардлын данс бууруулж 128.9 мянган төгрөгийн алдаатай бүртгэл хөтөлсөнийг санхүү байдлын тайланд;
- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 41,297.2 мянган төгрөгийн зардлыг цалингийн зардалд бүртгэж алдаатай тайлагнасныг орлого үр дүнгийн тайланд тус тус залруулсан.

Аудитаар нийт 347,529.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 344,232.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,296.9 мянган төгрөгийн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 347,529.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 340,781.6 мянган төгрөгөөр давсан байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

5.1 Албан шаардлага

1. Тус байгууллага нь нийт 344,232.1 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, чимэглэлийн сэлбэг хэрэгсэл болох бараа материалын худалдан авалтыг шууд гэрээ байгуулан гүйцэтгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, 44 дүгээр зүйлийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүй, бараа, ажил, үйлчилгээний төсөв өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын зохих аргыг хэрэглээгүй худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт-1: Бараа материалын худалдан авалттай холбоотой 3,296.9 мянган төгрөгийн анхан шатны баримт болох и-баримт шивүүлээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт материалын бүрдүүлэлтийг бүрэн хангах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангаар татварын авлагыг тооцооны үлдэгдлийн баталгаатай тулган баталгаажуулж тайлагнаагүй зөрүүтэй толилуулсан	1	9,948.9			1	9,948.9	1	9,948.9				
Санхүүгийн орлого үрдүгийн тайлангаар "Орлогын албан татварын зардал"-ыг алдаатай тайлагнасан.	1	945.9			1	945.9	1	945.9				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу бүртгэл хөтлөөгүйгээс Зардлын данс бууруулж алдаатай бүртгэл хөтөлсөн.	1	128.9			1	128.9	1	128.9				
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг "Цалингийн зардал"-д бүртгэж алдаатай тайлагнасан.	1	41,297.2			1	41,297.2	1	41,297.2				
Дүн	4	52,320.9			4	52,320.9	4	52,320.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын худалдан авалттай холбоотой анхан шатны баримт болох и-баримт шивүүлээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	3,296.9					1	3,296.9				
Гэрэлтүүлэг, чимэглэлийн сэлбэг хэрэгсэл худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна.	1	344,232.1			1	344,232.1						

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ ЧИМЭГЛЭЛИЙН АЛБАНЫ 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

Дүн		347,529.0		1	344,232.1	1	3,296.9			
------------	--	------------------	--	----------	------------------	----------	----------------	--	--	--

Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь шилэн дансандаа цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 5,368.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй байна.	1	5,368.0					1	5,368.0				
Тайлан онд тус байгууллага нь цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.	1	58,847.5					1	58,847.5				
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйл, 7.2.15.төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшуулалд НӨАТ ногдуулна гэж заасны дагуу санхүүжилтийн орлогоос НӨАТ тооцож бүртгээгүй байна	1	110,981.8			1	110,981.8						
Дүн	3	175,197.3			1	110,981.8	2	64,215.5				